



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 1/22

Шивээговь сум

Орон нутгийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийн сумын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Төслийг хамтран хэрэгжүүлэх тухай Хүүхдийг ивээх сангийн суурин төлөөлөгч болон аймгийн Засаг дарга нарын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн 2.8 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хүүхэд залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах сумын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Сумын Засаг дарга

Гишүүд:

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний

сум хариуцсан мэргэжилтэн

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

Залуучуудын холбооны тэргүүн

Бизнес эрхлэгчдийн төлөөлөл

Эцэг эхийн төлөөлөл

Сайн дурын идэвхтний төлөөлөл

Өсвөр үе, залуучуудын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Ерөнхий боловсролын сургуулийн

захирал

2.Төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, үр дүнг тооцож, хяналт тавин сар тутамд тайлагнаж ажиллахыг (Зөвлөл)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/10 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ